



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/109/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор:              Б.Нарангэрэл Утас: 99009293      Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

## Агуулга

2. Аудитын гэрчилгээ .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Албан шаардлага .....	17
4.3 Зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/68

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

• 005020551

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, starting with a large loop and extending across the stamp.

Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>244,583,929.85</u></b>	<b><u>814,501,615.83</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,075,000.00	4,280,000.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	1,075,000.00	4,280,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	1,075,000.00	4,280,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,075,000.00	4,280,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,667,000.00	80,093,993.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,667,000.00	35,380,583.70
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	44,713,409.30
3351	Байгууллагаас авах авлага	00.00	44,713,409.30
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	241,841,929.85	730,127,622.83
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	209,480,256.10	698,258,697.90
35110	Тусгай зориулалттай материал	21,342,991.10	22,451,416.10
35130	Эм боох материал	188,137,265.00	675,807,281.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	32,361,673.75	31,868,924.93
35410	Бичиг хэргийн материал	2,697,650.00	2,569,700.00
35420	Аж ахуйн материал	12,586,183.00	14,923,496.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,840,000.00	550,000.00
35440	Түлш, шатах тослох материал	11,668,190.00	1,957,308.18
35450	Барилгын засварын материал	1,411,800.00	9,510,570.00
35470	Бусад хангамжийн материал	2,157,850.75	2,357,850.75
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,089,153,876.73</u></b>	<b><u>1,069,320,109.29</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,089,153,876.73	1,069,320,109.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	923,277,001.82	904,050,734.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	817,245,798.51	817,245,798.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,177,492.48	-87,055,288.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	240,821,297.08	222,521,297.08
39204	Хуримтлагдсан элэгдэл	-141,557,963.74	-152,677,963.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,388,913.00	244,173,868.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-150,692,028.55	-167,183,803.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,853,080.44	138,862,896.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-106,275,602.44	-112,507,070.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,042,350.00	1,042,350.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-371,350.00	-371,350.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	165,876,874.91	165,269,374.79
39301	Програм хангамж	2,150,000.00	2,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-848,125.09	-1,455,625.21
39303	Бусад биет бус хөрөнгө	164,575,000.00	164,575,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,333,737,806.58</u></b>	<b><u>1,883,821,725.12</u></b>

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,644,482.00</b>	<b>71,380,683.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,644,482.00	71,380,683.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,644,482.00	71,380,683.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,644,482.00	70,910,683.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	470,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	470,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,330,093,324.58</b>	<b>1,812,441,042.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,330,093,324.58	1,812,441,042.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	755,146,079.04	755,146,079.04
51101	Өмч: - төрийн	755,146,079.04	755,146,079.04
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-181,241,563.41	301,106,154.13
51210	Өмнөх үеийн үр дүн	-181,241,563.41	-181,241,563.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	482,347,717.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	756,188,808.95	756,188,808.95
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,333,737,806.58</b>	<b>1,883,821,725.12</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,916,789,742.40</b>	<b>11,088,025,574.99</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>542,355,292.45</b>	<b>7,202,614,721.99</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	542,355,292.45	7,202,614,721.99
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,063,818.00	53,306,055.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	531,291,474.45	7,149,308,666.48
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,374,434,449.95</b>	<b>3,885,410,853.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,015,130,900.00	2,362,041,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,015,130,900.00	2,362,041,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>359,303,549.95</b>	<b>1,523,368,953.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	145,706,681.00	93,814,135.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,083,440.00	1,363,162,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,513,428.95	66,392,068.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,859,515,869.16</b>	<b>10,604,770,207.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,859,515,869.16</b>	<b>10,604,770,207.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,150,792,269.86	9,072,709,066.75
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	531,272,411.00	551,103,822.00
210101	Үндсэн цалин	531,272,411.00	426,095,606.00
210102	Нэмэгдэл	00.00	66,759,285.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	18,665,000.00
210104	Урамшуулал	00.00	39,583,931.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,547,918.01</b>	<b>76,397,183.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,635,007.01	53,863,803.03
210202	Тэтгэмжийн даатгал	5,516,479.00	6,233,718.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,278,782.00	4,761,855.28
210204	Ажилгүйдлийн даатгал	919,787.00	1,048,891.30
210205	Эрүүл мэндийн даатгал	9,197,863.00	10,488,915.48

**Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>79,912,056.38</b>	<b>89,157,807.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,554,906.38	7,329,039.00
210302	Түлш, халаалт	58,873,100.00	66,347,424.00
210303	Цэвэр, бохир ус	15,484,050.00	15,481,344.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>74,727,203.72</b>	<b>361,657,772.30</b>
210401	Бичиг хэрэг	9,817,290.00	13,393,150.00
210402	Тээвэр, шатахуун	43,053,785.00	46,300,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,661,850.72	5,275,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	443,200.00	427,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,646,353.00	21,272,439.00
210408	Бараа материал акталсны зардал	2,104,725.00	3,831,655.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал		271,158,248.30
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>825,553,373.22</b>	<b>6,422,251,212.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	825,553,373.22	6,422,251,212.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,906,483.73</b>	<b>14,779,150.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,296,443.73	00.00
210602	Тавилга	390,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,220,040.00	14,779,150.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,461,000.00</b>	<b>10,117,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,461,000.00	10,117,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>351,069,197.29</b>	<b>1,456,728,331.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	341,273,616.00	1,443,259,084.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	381,100.00	3,631,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	1,600,919.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	456,520.00	254,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,564,761.29	7,515,560.00
210807	Газрын төлбөр	648,600.00	390,180.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>181,342,626.51</b>	<b>90,516,288.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,630,100.00	6,292,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	850,000.00	1,083,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,862,526.51	83,141,288.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>708,723,599.30</b>	<b>1,532,061,140.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>679,938,926.00</b>	<b>1,485,529,183.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	343,582,886.00	453,087,597.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	330,801,440.00	1,014,766,986.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,554,600.00	17,674,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,784,673.30</b>	<b>46,531,957.74</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,453,063.30	44,065,324.74
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>331,610.00</b>	<b>2,466,633.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,466,633.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>57,273,873.24</b>	<b>483,255,367.50</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>56,709,811.87</b>	<b>907,649.96</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	56,709,811.87	907,649.96
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>564,061.37</b>	<b>-907,649.96</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>564,061.37</b>	<b>482,347,717.54</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,381,986,049.95</b>	<b>4,134,533,274.70</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,381,986,049.95</b>	<b>4,134,533,274.70</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,015,130,900.00	2,362,041,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,015,130,900.00	2,362,041,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	366,855,149.95	1,772,491,374.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	145,706,681.00	93,814,135.00
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,841,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,794,040.00	1,363,162,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,513,428.95	313,847,489.70
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,373,633,249.95</b>	<b>4,120,419,158.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,373,633,249.95</b>	<b>4,120,419,158.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,623,764,890.65</b>	<b>2,552,977,434.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	531,117,084.00	548,018,142.00
210101	Үндсэн цалин	334,273,321.00	330,382,434.00
210102	Нэмэгдэл	95,166,796.00	136,667,329.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,060,267.00	33,477,019.00
210104	Урамшуулал	52,616,700.00	47,491,360.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,580,898.01</b>	<b>74,875,165.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,791,499.86	52,681,100.51
210202	Тэтгэмжийн даатгал	5,326,078.09	5,652,223.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,254,121.14	4,474,798.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,064,499.51	1,096,885.77
210205	Эрүүл мэндийн даатгал	9,144,699.41	10,970,157.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>79,912,056.38</b>	<b>89,157,807.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,554,906.38	7,329,039.00
210302	Түлш, халаалт	58,873,100.00	66,347,424.00
210303	Цэвэр, бохир ус	15,484,050.00	15,481,344.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,388,382.72</b>	<b>40,098,236.00</b>
210401	Бичиг хэрэг	7,996,300.00	7,423,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,550,000.00	18,851,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,606,140.72	5,235,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,381,800.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,854,142.00	8,188,536.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>305,869,999.30</b>	<b>231,444,703.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	305,509,999.30	231,444,703.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	360,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,264,665.00</b>	<b>28,979,070.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	653,625.00	90,000.00
210602	Тавилга	705,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,950,000.00
210604	Урсгал засвар	7,906,040.00	25,939,070.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>6,461,000.00</b>	<b>10,117,500.00</b>
210702	Дотоод албан томиллолт	6,461,000.00	10,117,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>379,102,121.24</b>	<b>1,512,717,836.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	368,231,539.95	1,497,498,589.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	381,100.00	3,631,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	1,600,919.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	456,520.00	254,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,639,761.29	9,265,560.00
210807	Газрын төлбөр	648,600.00	390,180.00

**Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>209,068,684.00</b>	<b>17,568,975.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	206,988,684.00	16,485,975.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,080,000.00	1,083,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>749,868,359.30</b>	<b>1,567,441,724.44</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>719,416,686.00</b>	<b>1,485,529,183.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	343,582,886.00	453,087,597.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	369,279,200.00	1,014,766,986.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,554,600.00	17,674,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,451,673.30</b>	<b>81,912,541.44</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,453,063.30	44,065,324.74
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,998,610.00	37,847,216.70
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,352,800.00</b>	<b>14,114,116.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>12,277,800.00</b>	<b>10,909,116.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,277,800.00</b>	<b>10,909,116.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>12,277,800.00</b>	<b>10,909,116.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,277,800.00	10,909,116.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-12,277,800.00</b>	<b>-10,909,116.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-3,925,000.00</b>	<b>3,205,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,000,000.00</b>	<b>1,075,000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,075,000.00</b>	<b>4,280,000.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021.12.31

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-246,864,986.42	1,264,469,901.57
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>755,146,079.04</b>	<b>756,188,808.95</b>	<b>-246,864,986.42</b>	1,264,469,901.57
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	34,459,361.64	34,459,361.64
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-181,241,563.41	1,330,093,324.58
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-181,241,563.41	1,330,093,324.58
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>755,146,079.04</b>	<b>756,188,808.95</b>	<b>-181,241,563.41</b>	1,330,093,324.58
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	482,347,717.54	482,347,717.54
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	<b>301,106,154.13</b>	1,812,441,042.12

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021.12.31

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,370,041,900.00	2,317,976,575.26	52,065,324.7	97.8
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,370,041,900.00	2,317,976,575.26	52,065,324.7	97.8
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	853,912,700.00	832,447,392.26	21,465,307.7	97.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	556,871,000.00	548,018,142.00	8,852,858.0	98.4

**Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	372,554,800.00	330,547,177.00	42,007,623.0	88.7
210102	Нэмэгдэл	75,708,000.00	136,505,867.00	-60,797,867.0	180.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,975,000.00	33,477,019.00	18,497,981.0	64.4
210104	Урамшуулал	56,633,200.00	47,488,079.00	9,145,121.0	83.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>75,852,500.00</b>	<b>74,875,165.26</b>	<b>977,334.7</b>	<b>98.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	53,377,700.00	52,681,100.51	696,599.5	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,618,700.00	5,652,223.06	-33,523.1	100.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,495,000.00	4,474,798.44	20,201.6	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,123,700.00	1,096,885.77	26,814.2	97.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,237,400.00	10,970,157.48	267,242.5	97.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>89,975,300.00</b>	<b>89,157,807.00</b>	<b>817,493.0</b>	<b>99.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,100,900.00	7,329,039.00	771,861.0	90.5
210302	Түлш, халаалт	66,347,800.00	66,347,424.00	376.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	15,526,600.00	15,481,344.00	45,256.0	99.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,402,700.00</b>	<b>40,098,236.00</b>	<b>1,304,464.0</b>	<b>96.8</b>
210401	Бичиг хэрэг	7,500,000.00	7,423,000.00	77,000.0	99.0
210402	Тээвэр, шатахуун	18,851,300.00	18,851,300.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,235,400.00	5,235,400.00	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	1,316,000.00	400,000.00	916,000.0	30.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,500,000.00	8,188,536.00	311,464.0	96.3
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>4,833,350.00</b>	<b>166,650.0</b>	<b>96.7</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	4,833,350.00	166,650.0	96.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,526,000.00</b>	<b>32,558,970.00</b>	<b>2,967,030.0</b>	<b>91.6</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	2,889,900.00	1,610,100.0	64.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,983,600.00	2,950,000.00	33,600.0	98.9
210604	Урсгал засвар	28,042,400.00	26,719,070.00	1,323,330.0	95.3
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,806,700.00</b>	<b>10,117,500.00</b>	<b>689,200.0</b>	<b>93.6</b>
210702	Дотоод албан томилолт	10,806,700.00	10,117,500.00	689,200.0	93.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,439,000.00</b>	<b>15,219,247.00</b>	<b>1,219,753.0</b>	<b>92.6</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,631,100.00	3,631,000.00	100.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,645,600.00	1,600,919.00	44,681.0	97.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	254,588.00	225,412.0	53.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	77,000.00	55,000.0	58.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	9,265,560.00	634,440.0	93.6
210807	Газрын төлбөр	650,300.00	390,180.00	260,120.0	60.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22039500.00</b>	<b>17568975.00</b>	<b>4470525.0</b>	<b>79.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,948,200.00	16,485,975.00	4,462,225.0	78.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,091,300.00	1,083,000.00	8,300.0	99.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1516129200.00</b>	<b>1485529183.00</b>	<b>30,600,017.0</b>	<b>98.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,516,129,200.00</b>	<b>1,485,529,183.00</b>	<b>30,600,017.0</b>	<b>98.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэвэр	478,313,900.00	453,087,597.00	25,226,303.0	94.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,019,155,200.00	1,014,766,986.00	4,388,214.0	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,660,100.00	17,674,600.00	985,500.0	94.7
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,370,041,900.00</b>	<b>2,317,976,575.26</b>	<b>52,065,324.7</b>	<b>97.8</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,370,041,900.00</b>	<b>2,317,976,575.26</b>	<b>52,065,324.7</b>	<b>97.8</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,370,041,900.00	2,317,976,575.26	52,065,324.7	97.8
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>45.00</b>	<b>45.00</b>		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00		
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>45.00</b>	<b>45.00</b>		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	30.00	30.00		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	02.00	02.00		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00		

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>366,855,150.0</b>	<b>1,765,991,374.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>366,855,150.0</b>	<b>1,765,991,374.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	366,855,150.0	1,765,991,374.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	226,611,353.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		226,611,353.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	364,856,540.0	1,501,532,805.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	364,856,540.0	1,501,532,805.0
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,998,610.0</b>	<b>37,847,216.7</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,998,610.0	37,847,216.7
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	366,855,150.0	1,765,991,374.7
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	366,855,150.0	1,765,991,374.7
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	145,706,681.0	93,814,135.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,841,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,794,040.0	1,363,162,750.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,513,429.0	307,347,489.7
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		1,667,000.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг дарга Н.Энхжаргал, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ нар зурсан байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгахад оршино. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрүүл мэндийн яамны дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,859,515.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 28,595.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,016.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 74,233.4 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 550,083.9 мянган төгрөгөөр буюу 41.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	244,583.9	814,501.6	569,917.7
Мөнгөн хөрөнгө	1,075.0	4,280.0	3,205.0
Авлага	1,667.0	80,094.0	78,427.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	241,841.9	730,127.6	488,285.7
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,089,153.9	1,069,320.1	(19,833.8)
Үндсэн хөрөнгө	1,547,076.4	1,590,571.2	43,494.8
Хуримтлагдсан элэгдэл	(457,922.6)	(521,251.1)	(63,328.5)
<b>Нийт хөрөнгө</b>	1,333,737.8	1,883,821.7	550,083.9
Өр төлбөр	3,644.5	71,380.7	67,736.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,330,093.3	1,812,441.0	482,347.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,333,737.8	1,883,821.7	550,083.9

Авлагын дансны үлдэгдэл 78427.0 мянган төгрөгөөр өссөн нь 2021 онд сумдын эмийн сангуудаас авах авлага 44,713.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл болох 35,380.6 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 730,227.6 мянган төгрөг болж 488,285.7 мянган

<i>Хүснэгт №1 Үнэ төлбөргүй хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгсэл</i>	
Байгууллагын нэр	Мөнгөн дүн/мянган төгрөг/
ХӨСҮТ	5,385,296.70
Эрүүл мэндийн яам	770,149.40
Аймгийн онцгой комисс	690,875.30
Аймгийн ЗДТГ	214,697.20
Монгол эм импекс концерн	51,920.60
Мөнхийн тун ХХК	7,140.00
Юу Би Лаб ХХК	6,478.00
Монос Трейд ХХК	5,559.60
Баянгол мед ХХК	5,060.00
ЭНХ ТЭРГЭЛ ХХК	4,122.00
Сүвэн-Уул	2,880.00
Еврофарм ХХК	890.00
<b>Дүн</b>	<b>7,145,068.80</b>

төгрөгөөр өссөн нь аймгийн Онцгой комиссоос 690,875.3 мянга, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 5,385,296.7 мянга, Эрүүл мэндийн яамнаас 770,149.4 мянга, аймгийн ЗДТГ-аас 214,697.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан эм,

<i>Хүснэгт №2 Бусад байгууллагад хуваарилсан</i>	
Байгууллагын нэр	Мөнгөн дүн/мянган төгрөг/
Сумдын ЭМТ	148,769.5
Аймгийн ӨЭМТ	6,741.8
Нэгдсэн эмнэлэг	107,245.9
<b>Дүн</b>	<b>262,757.2</b>

эмнэлгийн хэрэгслийг дээрх хүснэгтэд заасан сумдын эрүүл мэндийн төвүүд, аймгийн өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хуваарилсан байна. Тайлант онд нийт 6,422,251.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулсан байна. Зарцуулсан эм, эмнэлгийн хэрэгслийн нийт 859,622.0 мянган төгрөг буюу 13.4 хувийг Ковидын оношлуур, 5,021,169.8 мянган төгрөг буюу 78.2 хувийг вакцин эзэлж байгаа бөгөөд 8.4 хувийг хамгаалах хэрэгсэл, бусад эм тариа эзэлж байна.

Мөн сумдын эрүүл мэндийн төвүүдэд олгох эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааны хууль журмын дагуу зохион байгуулж, нийт 290,056.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авч, 277,431.2 мянган төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгслийг олгосон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,590,571.2 мянган төгрөг болж 438,494.8 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/08, 2021 оны А/519 дугаар тушаалаар Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 33,650.6 мянган төгрөгийн өртөгтэй 7 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж, 2021 оны А/799 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яамнаас нэг бүр нь 1,965.6 мянган төгрөгийн өртөг бүхий 10 ширхэг компьютерыг үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр нийт 10,909.1 мянган төгрөгийн 7 нэр төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

Мөн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 45 дугаар тушаалаар 18.3 сая төгрөгийн анхны өртөгтэй тээврийн хэрэгслийг аймгийн Цагдаагийн газарт, 2,420.4 мянган төгрөгийн өртөгтэй тавилга эд хогшлыг аймгийн Зоонозын өвчин судлалын төвд үнэ төлбөргүй шилжүүлсэн.

Өглөгийн дансны үлдэгдэл 71,380.7 мянган төгрөг байгаа нь тайлант хугацааны эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагаатай холбоотойгоор нийт 13 эмийн компанид 70,910.7 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,812,441.0 мянган төгрөг болж 482,347.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 482,347.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 684,568.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 684,568.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,685,473.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 2,370,041.9 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд үүнд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 478,313.9 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс олгох дэмжлэг болох 1,019,155.2 мянган төгрөг багтсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,370,041.9 мянган төгрөгийн төсөв баталж ~~снаас 2,370,041.9 мянган төгрөгийг~~ улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,362,041.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,317,976.6 мянган төгрөгийг зарцуулж, 44,065.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,317,976.6 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 8,852.9 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 977.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 817.5 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,304.5 мянга, нормативд зардлыг 166.7 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 2967.0 мянга, томилолт зочны зардлыг 689.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 1,219.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,470.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1,363,162.6 мянга, ДЭМБ болон НҮБ-ийн хүүхдийн сангаас ирсэн хандив, тусламж 93,814.1 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 313,847.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулсан бөгөөд, үлдэгдэл 2,466.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 35,380.6 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлснийг санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Эрүүл мэндийн яамнаас нийт 12,400,000.0 мянга, орон нутгаас нийт 2,100,000.0 мянга, олон улсын төсөл хөтөлбөр, хандив тусламжаар нийт 625,900.0 мянган төгрөгийн нийт 15,100,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Тус байгууллага нь тайлант онд Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 5,374,041.3 мянган төгрөгийн вакцин үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн ба гүйцэтгэлээр нийт 5,021,169.8 мянган төгрөгийг вакциныг Ковид-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтад зарцуулсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилго, 27 зорилтын хүрээнд 101 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 89.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 10,604,770.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 7,745,254.3 мянган төгрөгөөр буюу 73.0 хувиар өссөн байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 5,596,697.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,105,985.5 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 683,965.6 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материалын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативд зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, эд хогшил, урсгал засварын зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд

хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 6,166,216.4 мянган төгрөгийн 90 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулсан байна. Тухайлбал:

Сумын эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг 302,212.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 25 багцад 272 нэр төрлийн эм, 40 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 27 нэр төрлийн урвалж оношлуур ханган нийлүүлэх тендер зарлагдсан бөгөөд 1-р шатанд 20 багцад ерөнхий шаардлага хангасан 12 эм ханган нийлүүлэх байгууллагатай 240,432.9 мянган төгрөгийн гэрээ хийсэн. Хоёр дахь шатны тендер шалгаруулалтад 5 багцын 54,355.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 3 багц дээр гэрээ байгуулж, 2 багц дээр шууд гэрээ байгуулсан байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 62,439.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,249.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 3,881.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 54,705.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,602.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.07.07-ны өдрийн 317 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 31,281.3 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 3744.4 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4089.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 23,447.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг хүргүүлээ.

### **4.1 Төлбөрийн акт**

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Уриалга хүргүүлэх тухай" захирамжаар малчдын өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор байгууллага бүр 100 мал худалдан авах уриалга гаргасны дагуу тус байгууллага нь бараа үйлчилгээний бусад зардлаас төл малын үнэнд 1875.0 мянга, өвс тэжээлийн үнэнд 1069.4 мянга нийт 2944.4 мянган төгрөгийг төсвөөс зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох буруутай албан тушаалтнаар 2,944.4 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Эрүүл мэндийн газрын даргын 2021.12.14-ны өдрийн А/174 дугаар тушаалаар Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан нэр бүхий 28 албан хаагчдыг урамшуулан нийт 8,000.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас олгохдоо хуулийн дагуу ХХОАТ-ыг суутгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох ажилтнуудаас ХХОАТ-ын 800.0 мянган төгрөгийг суутган, буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 4.2 Албан шаардлага

1. ЭМС-ын 2021 оны А/08 дугаар тушаалаар хуваарилсан 3,100.0 мянган төгрөгийн үнэтэй хөргөгч /VLS 064 RF/ -ийг тушаал шийдвэргүйгээр Эрдэнэцогт сумын ЭМТ-д шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 4 дүгээр сард 3 ажилтны цалин болох 989.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд мэдээлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 ” үнэн зөв байх, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, 17 дугаар зүйлийн 17.1 “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх 3 ажилтны нийгмийн даатгалын санд мэдээлээгүй 989.9 мянган төгрөгийн цалинг нөхөн мэдээлж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгөв.

#### 4.3 Зөвлөмж

1. ЭМС-ын 2021.03.04-ны А/102 дугаар тушаалаар хуваарилсан хөрөнгүүд зөрүүтэй ирсэн байна. Жишээлбэл: Нэг удаагийн маск 40 ширхэг, нүүрний хамгаалалт 5000 ширхэг, нэг удаагийн бээлий 30, нэг удаагийн маск 30 ширхэг, нийт 23,447.0 мянган төгрөгийн хувийн хамгаалах хэрэгсэл тус тус дутуу ирсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид Эрүүл мэндийн яамнаас ирсэн хөрөнгө оруулалтыг, анхан шатны баримттай нь тулгаж, бүрэн хүлээж авах тал дээр анхаарч ажиллан өмнөх

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

онд дутуу ирсэн хөрөнгийг ирүүлэх талаар албан тоотор хандаж асуудлыг шийдвэрлүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар	5	31,281.3	0	0	2	3,744.4	2	4,089.9	1	23,447.0

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_